

ЕБС-ИЙН СУРАГЧДАД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН БАРИМЖАА ОЛГОЖ БУЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

Д.Мөнхжаргал, Д.Бат-эрдэнэ, МУБИС

Abstract

The purpose of this study is to uncover the current situation of career guidance and counseling for secondary schools in Mongolia. Totally 566 people participated in the study including class teachers, school managers, social workers, and students. The study adopted a mixed methodology which includes policy analysis, survey questionnaire, and interviews.

The main results and conclusions are the followings: Legal and policy statements on career guidance are not implemented in real school life and its financial mechanism is not clear. There are no regulations and procedures regarding who is responsible for, how to manage career guidance services. There is a gap between traditional and contemporary attitudes toward career guidance services. School teachers are still focusing on professional training, specialized courses, and entrance exams instead of diagnosing and developing student's personal traits for vocation choice.

Schools do not have a counseling center and provide limited manuals and handouts for students. More than 50% of surveyed students, indeed, expressed dissatisfaction with career guidance services. Students who enroll in rural or isolated urban schools cannot access career guidance services. Instead of school teachers, students choose their parents, relatives and internet as the close advisors for their career choice. Students do not choose their professions based on their personal traits.

Түлхүүр үг

Ажил мэргэжлийн баримжаа, мэргэжил сонголт, авьяас, чадварын оношилгоо

Удиртгал

Монголчууд бид “Биеэ мэдвэл хүн, бэлчээрээ мэдвэл мал” хэмээн хүн хүчнийхээ онцлогийг тодруулж, “Цэр нь цээжид, бөөр нь бөгсөнд” хэмээн тэдний чадвар, чадамжийг оновчтой ашиглан нийгэм журмыг тогтоож ирсэн уламжлалтай. Харин өнөөдөр энэхүү уламжлал алдагдаж хүн хүчний бодлого нь эмх журамгүй, эрэмбэ дараагүй төлөвт шилжиж улмаар нийгмийг тогтворшилгүй байдал руу түлхэж болзошгүй байдал үүслээ. Тогтвортой хөгжил бүхий, тулхтай нийгэм цогцлоох зорилгод хүрэх үндсэн нөхцөлүүдийн нэг бол ажил мэргэжилдээ сэтгэл зүрхээ зориулсан, эрдэм билиг, арга ухаан нь зохирсон хүн хүч юм. Ийм дүр төрхтэй хүн хүчийг буй болгох анхдагч алхмуудын нэг нь өсвөр, хойч үедээ ажил мэргэжлийн баримжаа олгох боловсролын үйлчилгээ байдаг. Энэхүү үйлчилгээний хүртээмж, чанарын асуудлын өнөөгийн нөхцөл байдлыг судалж, үүндээ үндэслэн сайжруулах арга замыг тогтоох шаардлага тулгарч буй.

Онолын үндэслэл

Ажил мэргэжлийн баримжааны

судалгаанд Парсонс, Холланд нарын хувь хүний онцлог, авьяас, чадварт ажил мэргэжлийг нийцүүлснээр хөдөлмөрийн бүтээмж өндөр төвшинд хүрдэг гэсэн функциональ онол /Trait and Factors Theory/, Крамболц, Сүүпэр нарын нийгмийн орчноос олж авсан туршлагаар хувь хүний мэргэжлийн чадвар нь насан туршдаа арвижин хөгждөг гэсэн хөгжлийн онол /Social Learning Theory/ гэсэн 2 үндсэн онолын чиглэлийг баримталдаг. Энэхүү судалгааны ажил нь Холландын функциональ онолд үндэслэж байгаа болно.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ажил мэргэжлийн баримжаа олгох ажлын нөхцөл байдлыг судлан тогтоох, энэ чиглэлийн ажлыг сайжруулахад зөвлөмж өгөхөд оршино. Тавигдсан зорилгыг биелүүлэхийн тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Ажил мэргэжлийн баримжаа олгох бодлогод дүн шинжилгээ хийх,
- Сургуулиудад ажил мэргэжлийн

* ✉ munkhjargal@msue.edu.mn

баримжаа олгох ажлын удирдлага, зохион байгуулалтын байдлыг тодруулах,

- Сургуулиудад ажил мэргэжлийн баримжаа олгох ажлын төрөл, агуулгыг тодорхойлон гаргах,
- Энэхүү ажлыг гүйцэтгэхэд оролцож буй субъектүүд, тэдний үүрэг оролцоог нарийвчлан судлах,
- Ажил мэргэжлийн баримжаа олгох ажлын үр дүнг тооцох
- Сурагчдын мэргэжил сонгож буй үндэслэлийг судлах зэрэг болно.

Уг судалгаанд баримт материал судлах, асуулга болон ярилцлага зохион байгуулах гэсэн 3 аргыг голчлон хэрэглэсэн болно. Судалгааны ажилд хэрэглэх багш болон сурагчийн гэсэн 2 төрлийн асуулгыг боловсруулан гаргаж, нийслэлийн зарим сургуулийн багш, сурагчдад туршин үзсэний үндсэн дахин сайжруулан боловсронгуй болгож хэвлүүлсэн. Багш нарын асуулгыг 18, харин сурагчдынхыг 20 асуулттайгаар боловсруулсан.

Сургууль бүрээс 3 хүнтэй ярилцлага зохин байгуулсан бөгөөд үүнд сургалтын менежер, нийгмийн ажилтан болон анги удирдсан багш оролцсон. Ярилцлагыг нээлттэй байдлаар зохион байгуулсан. Сурагчдаас нийт 516 судалгааны асуулга бөглүүлж авснаас 495 асуулгыг хүчинтэйд тооцсон. Харин багш нараар бөглүүлж авсан 71 асуулгын бүгдийг хүчинтэйд тооцож авсан. Excel, SPSS программ ашиглан боловсруулалт хийсэн.

Судалгааны үр дүн

1. Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний бодлого, зохицуулалт

“Бага, дунд боловсролын тухай” хуулийн “Бүрэн дунд боловсролын агуулга”-гэсэн бүлэгт “Мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан амьдарч, хөдөлмөрлөх, үргэлжлүүлэн суралцахад бэлтгэх” зорилтыг хэрэгжүүлнэ гэж заасан байдаг нь эрх зүйн хамгийн гол зохицуулалт юм. Хуулийн энэхүү заалтыг сургууль дээр хэн хариуцан хэрэгжүүлж байгаа нь тодорхойгүй байна. 2006 оны БСШУ-ны сайдын “Бодлого, төлөвлөгөө, бүтэц батлах тухай” тушаалд “Ахлах сургуулийн хичээлийн агуулга нь заавал судлах хичээл, сонгон судлах хичээл, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт гэсэн хэсгээс тогтоно” гэж зааж өгсөн нь мэргэжлийн чиг баримжаа олгох нь боловсролын агуулгын хэсэгт зайлшгүй багтах ёстойг илэрхийлж байна.

“Бага, дунд боловсролын тухай” хуульд

ерөнхий боловсролын сургуулиудыг ердийн, мэргэжлийн, гүнзгийрүүлсэн, төрөлжсөн сургалттай гэж ангилан чиг үүргийг тодорхойлж өгсөн байдаг. Улсын хэмжээнд 40 гаруй мэргэжлийн сургалттай ерөнхий боловсролын сургуульд мэргэжил эзэмшүүлэх сургалт явуулж байна. Ердийн сургалттай сургуульд ч гэсэн энгийн мэргэжил эзэмшүүлэх сургалт явуулах бүрэн боломжтой юм. Харин ахлах ангийн бүх сурагчдад зориулсан мэргэжлийн баримжаа олгох томоохон үйлчилгээг сургууль дээр хэн хариуцан зохион байгуулах нь тодорхойгүй, эрх зүйн зохицуулалт, хөрөнгө санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй байна. Боловсролын салбарын санхүүжилтэд мэргэжлийн баримжаа олгоход зориулж тухайлсан зардал төсөвлөдөггүй ажээ.

2009 онд БСШУ-ны болон НХХ-ийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Боловсролын нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолт”-д ажил мэргэжлийн баримжаа олгох чиг үүрэг оруулж өгөөгүй байна. Иймд нийгмийн ажилтан энэ үүргийг гүйцэтгэх үүрэг хүлээгээгүй байна.

2007 онд баталсан БСШУ-ны сайдын тушаалаар батлагдсан “Сургуулийн сургалтын менежерийн ажлын байрны тодорхойлолт”-д мэргэжлийн баримжааны асуудал мөн орхигдсон байна. Сургуулийн захирлын ажлын байрны тодорхойлолтод энэ асуудал мөн тусгагдаагүй байна.

Анги удирдсан багшийн ажлын байрны тодорхойлолт батлагдан гараагүй, анги удирдсан багш ямар чиг үүрэгтэй болох нь тухайн сургуулийн дотоод журмаас хамаарч байгаа тул үндэсний хэмжээнд энэ чиг үүргийг анги удирдсан багш хариуцна гэсэн зохицуулалт байхгүй байна.

Ерөнхий боловсролын сургуулиудын дотоод журамд анализ хийж үзэхэд ажил мэргэжлийн баримжаа олгох үүргийг нэг хэсэг нь сургалтын менежер, нөгөө хэсэг нь нийгмийн ажилтанд, бусад хэсэг нь анги удирдсан багшид хариуцуулдаг нэгдмэл бус дүр зураг ажиглагдаж байна.

2. Ажил мэргэжлийн баримжаа олгох ажлын зохион байгуулалт

Судалгаанд оролцсон багш нарын 88,7% нь, сурагчдын 80,0% нь сургуульд тухайлсан мэргэжлийн баримжаа олгох төв байдаггүй гэж хариулсан нь сургууль дээр энэ ажил нэгдсэн зохион байгуулалтад ороогүй байгааг илэрхийлж байна.

Ярилцлагад оролцсон багш, ажилчид энэ талаар их, дээд сургууль, төрийн бус

байгууллагуудаас ирэх хүмүүст найддаг, сургууль дээр хичээллүүлдэг дугуйлан, сонгон суралцах хичээлээс хэтэрдэггүй байна. Харин тухайлсан төвөөр дамжуулан ажил, мэргэжлийн талаар зөвлөгөө өгдөг ажил бараг хийгддэггүй байгаа нь тогтоогдсон.

Мэргэжлийн баримжаа олгох ажлын давтамжийг судалж үзэхэд судалгаанд оролцсон сурагчдын 16,4% нь мэргэжлийн чиг баримжааны зөвлөгөө нэг ч удаа аваагүй гэж хариулсан бол 42,0% нь жилийн туршид 1-2 удаа зөвлөгөө авсан гэж хариулсан нь тун хангалтгүй үзүүлэлт юм.

Хүснэгт 1

Мэргэжлийн баримжаа олгох зөвлөгөөний давтамж /жилээр/

	Ерөөсөө аваагүй	1-2 удаа	3-5 удаа	5-аас дээш удаа	Хариул аагүй
Хот	75	72	24	17	11
Хөдөө	81	139	35	33	7
Дүн	156	211	59	50	18

Танай сургуульд мэргэжлийн баримжаа олгох ямар ажлууд зохиогддог вэ? гэсэн дараачийн асуултад сурагчдын 28% нь ямар ч ажил зохиогддоггүй, 7,2% нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн бол багш нарын 14% нь ямар ч ажил зохиогдоггүй гэж хариулжээ. Энэ үзүүлэлт нь сургууль дээр мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний зохион байгуулалт хангалтгүй төвшинд байгааг давхар баталж байгаа юм.

Ярилцлагын явцад судалгаанд оролцсон сургуулиудад мэргэжлийн баримжаа олгох, мэргэжил эзэмшүүлэх ямар төвүүд үйл ажиллагаа явуулж байгаа талаар тодруулсан. Судалгаанд хамрагдсан бүх сургуулиуд ажил мэргэжлийн баримжаа олгох зориулалтын төвгүй байна. Харин хоёр сургууль төсөлд хамрагдаж мэргэжлийн түр сургалтын төв байгуулан ажиллуулж байгаа болно. Нийслэлийн 24-р сургуулийн Хүүхэд хөгжлийн “VISTA” төв нь үсчин гоо сайхан, компьютер, гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засварын чиглэлээр сурагчдад түр сургалт явуулдаг байна. Хэнтий аймгийн Биндэр сумын сургууль нь үсчин гоо сайхан, хөдөө аж ахуй, ардын гар урлалын чиглэлээр түр сургалт явуулдаг ажээ. Эдгээр сургуулиудын мэргэжлийн сургалтын төвийн үйл ажиллагааг технологийн багш нар хариуцан ажилладаг байна. Харин үлдсэн 3 сургуульд тухайлсан мэргэжлийн сургалтын төв байдаггүй. Энэ бүхнээс дээрх сургуулиудад мэргэжлийн баримжаа олгох, тодорхой мэргэжлийн сургалт явуулах нэгдсэн удирдлага, зохион байгуулалт

муутай, эрх зүйн зохицуулалт дутмаг байгаа нь харагдаж байна.

3. Ажил мэргэжлийн баримжаа олгох ажлыг хариуцах субъектүүд

Мэргэжлийн баримжаа олгох ажлын голлох субъектүүд нь хэн болох, тэдгээрийн үүрэг оролцоог тодруулж үзвэл дараах дүр зураг харагдаж байна. Судалгаанд оролцсон сурагчдын дунд “Ажил мэргэжлээ сонгох, энэ талын мэдээлэл олж авахад чамд хамгийн ойрын туслагч нь хэн байсан бэ?” гэсэн асуултад сурагчдын 66% нь эцэг эх, 43,4% нь ах эгч, 35,4% нь найз нөхөд гэж хариулсан. Харин судалгаанд оролцсон сурагчдын 22,0% нь анги удирдсан багшаа, 10,3% нь хичээл заадаг мэргэжлийн багш нараа, 2,6% нь нийгмийн ажилтанг ажил мэргэжлийн талаар зөвлөн туслагч гэж үзжээ.

Эндээс дүгнэж үзэхэд сурагчдын мэргэжил сонгох, энэ талаар зөвлөгөө авах нь гол төлөв гэр бүлийн хүрээнд өрнөж, энэ талын үйлчилгээнд сургуулийн оролцоо бага байгааг илэрхийлж байна. Ялангуяа мэргэжлийн баримжааны чиглэлээр зөвлөгөө өгөх чиг үүрэг хүлээсэн нийгмийн ажилтны оролцоо туйлын бага байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Интернетийг өөрийн зөвлөн туслагч гэж үзэх сурагчид 11,5%-ийг эзэлж байгааг анхаарч үзүүштэй баримт юм. Хөдөөгийн хүүхдүүд хотын хүүхдүүдийг бодвол анги удирдсан багшийн туслалцааг илүүтэй авдаг бол интернетийг хотын хүүхдүүд илүүтэй туслагчаа гэж үздэг байна.

Судалгаанд оролцсон сурагчдын 22,0% нь анги удирдсан багшийг энэ асуудлаарх ойрын туслагч гэж үзсэн бол багш нарын 74,6% нь өөрсдийгөө тэдний ойрын туслагч гэж үзжээ. Багш нар өөрсдийгөө мэргэжлийн баримжааны талаар сурагчдын ойрын туслагч гэж бодож явдаг ч сурагчдад өөр дотнын туслагч олон байдаг байна. Багш, сурагчид нэг зүйлийг адилхан хариулсан нь нийгмийн ажилтанг ойрын туслагчид оруулж тооцоогүй байна.

“Чиний ирээдүйн мэргэжлээ сонгоход хамгийн их нөлөөлсөн хүн хэн бэ?” гэсэн асуултад сурагчдын 79,8% нь эцэг эх, 47,1% нь ах эгч, 36,6% нь найз нөхөд гэж хариулсан нь дээрх асуултын хариулттай тохирч байгаа бөгөөд эдгээр хариултуудын корреляци хамаарал 0,64 байна. Анги удирдсан багшийг 27,5%, хичээл заадаг мэргэжлийн багш нарыг 13,1%, нийгмийн ажилтныг 4,2% нь тэдний мэргэжил сонгоход нөлөөлсөн гэж үзжээ. Иймээс мэргэжил сонгоход хамгийн их нөлөөлөл гэр бүлийн хүрээнд байна гэсэн дүгнэлт хийж болох юм.

Хүснэгт 2

Сурагчдад мэргэжлээ сонгоход нөлөөлсөн субъектүүд

	Эцэг эх	Эмээ өвөө	Нийгмийн ажилтан	Мэргэжлийн хүмүүс	Ах эгч	Мэргэжлийн багш	Интернет	Мэргэжил сургалтын төв	Найз нөхөд	Ангийн багш	Ном хэвлэл	Ахлах ангийнхан
Хот	164	33	5	39	96	33	27	4	67	44	15	5
Хөдөө	231	35	16	33	137	32	21	6	114	92	41	11
Дүн	395	68	21	72	233	65	48	10	181	136	56	16
Хувь	79.8	13.7	4.2	14.5	47.1	13.1	9.7	2.0	36.6	27.5	11.3	3.2

Сургууль дээр мэргэжлийн баримжааны асуудлыг хэн хариуцан ажилладаг вэ? гэсэн асуултад 42,4% нь анги удирдсан багш, 20,6% нь нийгмийн ажилтан, 17,2% нь хичээл заадаг мэргэжлийн багш, 7,3% нь сургалтын менежер

гэж хариулсан байна. Эндээс харахад мэргэжлийн баримжааны асуудлыг сургууль дээр ямар этгээд хариуцдаг нь ойлгомжгүй, нэгдсэн ойлголтот хүрээгүй байдал ажиглагдаж байна.

Хүснэгт 3

Мэргэжлийн баримжааны асуудлыг хариуцдаг субъектүүд

	Ангийн багш	Нийгмийн ажилтан	Сургалтын менежер	Мэргэжлийн багш	Мэдэхгүй	Хариулаагүй
Хөдөө	145	62	21	46	5	16
Хувь	49.2	21.0	7.1	15.6	1.7	5.4
Хот	65	40	15	39	0	41
Хувь	32.5	20	7.5	19.5	0	20.5
Дүн	210	102	36	85	5	57
Хувь	42.4	20.6	7.3	17.2	1.0	11.5

Багш нарын 36,6% нь анги удирдсан багш, 12,7% нь нийгмийн ажилтан, 23,9% нь хичээл заадаг мэргэжлийн багш, 18,3% нь сургалтын менежер хариуцдаг гэж хариулснаас үзэхэд багш нар ч сурагчдын нэгэн адил мэргэжлийн баримжааны асуудлыг хэн хариуцдаг талаар нэгдсэн ойлголтгүй явдаг байна.

Ярилцлагын явцад сургууль дээр мэргэжлийн баримжаа олгох асуудлыг хэн албан ёсоор хариуцдаг гэдгийг тодорхойлж чадаагүй. Сургуулиуд өөрсдийн байгууллагын дотоод журамдаа энэ талаар тодорхой тусгаагүй байгаа нь харагдсан. Энэ ажлыг хариуцан ажиллаж буй субъектүүд янз бүрийн албан тушаалтан байна. Тухайлбал, Нийслэлийн 24-р сургууль, Хэнтий аймгийн Биндэр сумын сургуулийн хувьд техник, технологийн багш нар голлох үүрэгтэй оролцож байгаа бол Төв аймгийн Сүмбэр суманд анги удирдсан багш зонхилдог байна. Нийслэлийн 113-р сургууль нийгмийн ажилтандаа энэ үүргийг албан бус замаар хариуцан ажиллахыг

даалгасан бол Архангай аймгийн Хашаат сумын сургуульд сургалтын менежер нь голлох үүргийг гүйцэтгэдэг ажээ.

4. Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний төрөл, агуулга

Дараагийн асуудал бол сургууль дээр явуулж буй ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний төрөл, хэлбэр, агуулгыг тогтооход чиглэгдсэн. Энэ зорилтын хүрээнд 1 асуултыг нээлттэй болон сонгох гэсэн 2 төрлөөр оруулж өгсөн. Нээлттэй хариулах асуулт нь “Танай сургуульд ажил мэргэжлийн баримжаа олгох талаар ямар ажлууд зохиогддог вэ?” гэсэн асуулт байсан бол энэ асуултыг дахин тодруулж “Танай сургууль дээр ажил мэргэжлийн баримжаа олгох ямар төрлийн үйлчилгээ үзүүлдэг вэ? Хамгийн чухал гэсэн 3 хариултыг сонгоно уу.” гэсэн 12 сонгох хариултаас 3-ыг сонгож дугуйлах асуулт байсан.

Эхний асуултад 57 сурагч лекцэд суусан, 57 сурагч сонгон, дугуйланд хамрагддаг, 24 сурагч уулзалт, ярилцлагад орсон, харин 10 сурагч л мэргэжлийн баримжааны зөвлөгөө авсан гэж хариулсан. Энэ асуултад 139 сурагч

мэргэжлийн баримжаатай холбогдох ямар ч ажил зохиогддоггүй, харин 36 сурагч мэдэхгүй хэмээн хариулсан нь судалгаанд оролцсон сурагчдын 35% нь мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээнд хамрагдаагүйг гэрчилж байна.

Хүснэгт 4

Сургуулиас зохион явуулсан ажил үйлчилгээ /Нээлттэй хариулт/

	Лекц	Ангийн багшийн дэмжлэг	Сонгон	Зөвлөгөө	Уулзалт	Судалгаа	Сургалт	Зохиодоггүй	Мэдэхгүй
Хот	40	0	37	2	0	1	2	38	27
Хөдөө	17	8	20	8	24	11	13	101	9
Дүн	57	8	57	10	24	12	15	139	36

Дээрх нээлттэй хариулах асуултыг нарийвчлан сонгох хариулттай болгон өөрчилж дүнг нь харьцуулан авч үзье. Сурагчдын 58,2% нь элсэлтийн шалгалттай холбогдох мэдээлэл,

38,2% нь ажил мэргэжил сонгох зөвлөгөө, 34,1% нь мэргэжлийн тухай мэдээлэл, 30,1% нь мэргэжлийн сургуулиудын талаарх мэдээлэл гэсэн үйлчилгээ авдаг гэж сонгожээ.

Хүснэгт 5

Сургуулиас зохион явуулсан ажил үйлчилгээ /сонгох хариулт/

	Мэргэжлийн мэдээлэл	Ажлын мэдээлэл	Сургуулийн мэдээлэл	Элсэлтийн мэдээлэл	Өөрийгөө таних	Мэргэжил сонгох зөвлөгөө	Мэргэжлийн сургалт
Хот	68	23	49	117	47	86	42
Хөдөө	101	34	100	171	78	103	57
Дүн	169	57	149	288	125	189	99
Хувь	34.1	11.5	30.1	58.2	25.3	38.2	20

Харьцуулсан судалгааны дүнгээс харахад, ажил мэргэжлийн баримжааны талаар явуулж буй ажил үйлчилгээний хүртээмж хомс байгаа нь ажиглагдаж байна. Ялангуяа, мэргэжил сонгох зөвлөгөөнд хамрагдсан сурагчдын эзлэх хувь харьцангуй бага байгааг харж болно.

Сургуулиудад мэргэжлийн баримжаа олгож буй ажил нь 2 үйл ажиллагаанд голлон төвлөрдөг гэж ойлгож болно. Сургуулиуд элсэлтийн шалгалтыг зохион байгуулах, шалгалт явуулах дэг журмыг сурагчдад танилцуулах, тэднийг элсэлтийн шалгалтад бэлтгэх ажлаа мэргэжлийн баримжаа олгох ажлын гол хэсэг гэж үздэг нь ярилцлагын явцад тодорсон.

Ажил мэргэжлийн баримжаа олгох зөвлөмж, гарын авлага нэн хомс байгаа нь дараах хүснэгтийн агуулгаас харагдаж байна. Судалгаанд хамрагдсан сургуулиуд БМИҮЗ болон их, дээд сургуулиудын консорциумаас гаргадаг их, дээд

сургуулийн элсэлтийн лавлахыг номын сангаараа дамжуулан төгсөх ангийн сурагчдад хүргэдэг. Үүнээс өөр мэргэжлийн байгууллагаас гаргасан мэргэжлийн баримжаа олгох ажилд хэрэглэх гарын авлага, зөвлөмж материал байдаггүй, хэрэглэдэггүй ажээ.

Судалгаанд хамрагдсан сургуулиуд өнгөрсөн жил болон энэ хичээлийн жилд мэргэжлийн баримжаатай холбогдон зохион байгуулсан ажлуудыг нэгтгэн гаргая. Нийслэлийн 24-р сургуулийн хувьд боловсролын үзэсгэлэн яармагт оролцох, их, дээд сургуулиудын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулах, сурагчдын эцэг эхийн ажлын газраар аялах зэрэг ажлыг зохион байгуулж хэвшсэн нь хотын сургуулийн давуу талыг харуулж байна. Хөдөөгийн сургуулийн хувьд Биндэр сумын сургуулийн хувьд гаднын байгууллагатай хамтран төсөл хэрэгжүүлэх, хөтөлбөрт хамрагдах туршлагатай

тул мэргэжлийн баримжаа олгох зориулалтгүй ч гэсэн дам утгаар нөлөөлөх төрөл бүрийн сургалт, уулзалтыг зохион байгуулдаг байна. Хөдөөгийн болон хотын захын сургуулиудын хувьд мэргэжлийн баримжаатай холбогдох ажил, үйлчилгээний төрөл цөөн, ийм ажил зохион байгуулах боломж хомс байдаг нь ажиглагдлаа.

5. Мэргэжил сонгосон үндэслэл

Ирээдүйд эзэмших мэргэжил, ажил хөдөлмөрийн сонголтоо юунд үндэслэж хийсэн бэ? гэсэн асуултад өөрийн сонирхолд үндэслэсэн гэж 36,2% нь, хүсэл мөрөөдлөө биелүүлэх гэж 5,3% нь сонголт хийсэн гэж хариулсан. Оролцсон нийт Хүснэгт 6

Мэргэжил сонгосон үндэслэлүүд

	Сонирхол	Мөрөөдөл	Авьяас	Хичээлдээ сайн	Бусдын санал	Амьдралын шаардлага	Гэр бүлийн уламжлал	Цалин	Ажлын байр	Сонгоогүй	Мэдэхгүй	Хариулаагүй
хот	75	10	13	3	13	9	2	8	17	28	7	15
хөдөө	104	16	8	11	10	20	5	5	19	48	23	26
дүн	179	26	21	14	23	29	7	13	36	76	30	41
хувь	36.2	5.3	4.2	2.8	4.6	5.9	1.4	2.6	7.3	15.4	6.1	8.3

Сурагчдын хувьд өөрийн сонгож авсан мэргэжил, түүнд шаардагдах авьяас чадвартай нийцэж байгааг шалгаж тогтоосон зүйл бий эсэх талаар асуусан асуултад сурагчдын 50,3% нь үгүй гэж хариулжээ. Эндээс харахад сурагчдын авьяас, чадварыг оношлох, өөрийнхөө зан чанарыг танин мэдэх, хөгжүүлэх, түүнд нь нийцсэн мэргэжлийг сонгуулах ажлууд бараг хийгддэггүй байна.

6. Сургуулиас явуулж буй үйлчилгээний үр дүн, сэтгэл ханамж

Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний чанар, үр дүн ямар төвшинд байгаа талаар асуултад хэрхэн хариулсныг авч үзье. Сургууль дээр зохиогдож байгаа ажил үйлчилгээний талаар судалгаанд оролцогчдын 8,1% нь маш үр дүнтэй, 37,2% нь үр дүнтэй, 36,2% нь үр дүнгүй, 11,3% нь огт үр дүнгүй гэж хариулжээ. Үүнээс үзэхэд сургуулиас явуулж буй үйлчилгээнд 45,3% нь эерэг, харин 47,5% нь сөрөг дүгнэлт өгчээ. Асуулгаас үзэхэд 74,5% нь сүүлийн 3 сард сургалтад хамрагдаагүй, 65,7% нь ямар нэгэн арга, техникт суралцаагүй байна. Эндээс сургууль дээр мэргэжлийн баримжааны сургалтуудыг тогтмол бус алдаг оног явуулж буйн зэрэгцээ явуулсан сургалтууд нь хангалттай

суралцагчдын 41,5% нь өөрийн хүсэл сонирхол, мөрөөдөлдөө хөтлөгдөн мэргэжлээ сонгосон нь харагдаж байна. Харин сурагчдын дөнгөж 4,2% нь өөрийн авьяас чадварын дагуу, 2,8% нь тухайн мэргэжлийн хичээлд сайн учраас сонгосон гэжээ. Оролцогчдын 15,4% нь мэргэжлээ сонгоогүй, 6,1% мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Эдгээр статистик үзүүлэлт нь сургуулиудад мэргэжлээ хэрхэн сонгох, өөрийн авьяас чадварт нийцүүлэн мэргэжлээ сонгох зэрэг зөвлөгөө, сургалт маш цөөхөн зохион байгуулдаг, зохион байгуулсан ч үр дүн муутай байдгийг нотолж байна.

үр дүнд хүрээгүйг харуулж байна. Эдгээр асуултуудад хариулсан байдлын корреляци нь 0,8 байна.

7. Ярилцлагын хураангуй

Ярилцлагад БСШУЯ-ны газрын дарга, мэргэжилтэн, Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, ЕБС-ийн сургуулиудын удирдах ажилтан, сургалтын менежер, анги удирдсан багш, нийгмийн ажилтан нар оролцсон.

Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээг сургууль дээр хэн хариуцаж байгаа талаар зөрүүтэй санал бодолтой байгаа нь ажиглагдаж байна. Тэд ярилцлагын явцад энэ үйлчилгээг хариуцдаг гэж сургуулийн захирал /4/, сургалтын менежер /5/, анги удирдсан багш /5/, нийгмийн ажилтан /6/, мэргэжлийн багш нар /4/, сургуулийн зөвлөл /1/ тус тус хариулжээ. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ажлыг хариуцдаг нэгж байдаг эсэхэд байдаг /3/, байдаггүй /5/, мэдэхгүй /2/ гэж хариулсан байна.

Хүүхдийн авьяас чадварыг оношлох, хөгжүүлэх талаар ямар ажлууд зохиогдож байгаа талаар дугуйлан секц ажиллуулдаг /8/, гүнзгийрүүлсэн сургалт явуулдаг /5/ гэж хариулжээ. Ажил мэргэжлийн баримжаа олгох

үйлчилгээ үзүүлэхэд тулгарч буй бэрхшээлийн талаар асууж тодруулахад, санхүүгийн боломж муу /2/, үйлчилгээ үзүүлэх байр, танхимгүй /5/, цалин хөлс урамшуулал байхгүй /3/, тоног төхөөрөмж байхгүй /1/, ажлын ачаалал их /1/, нэгдсэн мэдээлэл хомс /1/ гэж хариулсан байна.

Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээг сайжруулахад ямар үйл ажиллагаа зохион байгуулах шаардлагатай вэ гэсэн асуултад а/ нэгдсэн бодлого хэрэгжүүлэх, б/ мэргэжил сурталчлах төвүүд байгуулах, в/ үйлдвэр, үйлчилгээний газруудтай танилцуулах, г/ багш нарт зориулсан гарын авлага гаргах, д/ мэргэжлийн онцлогийг тусгасан сурталчилгааны материал тараах, сурталчилгаанаас гадна практик дадал, чадварын сургалт явуулах зэрэг саналуудыг дэвшүүлсэн байна.

Дүгнэлт

Бодлого, эрх зүйн зохицуулалтын хувьд “Бүрэн дунд боловсролын тухай хууль”-д мэргэжлийн баримжаа олгох, түүний агуулгын талаар тодорхой тусгасан, ЕБС-д сургалтын агуулгын уялдаа холбоог хангах чиглэлд тодорхой ажлуудыг хийж эхэлсэн зэрэг эерэг талууд байгаа боловч дээрх хуульд тусгагдсан мэргэжлийн баримжаа олгох үйл ажиллагаа сургуулийн амьдралд албан ёсоор хэрэгждэггүй, уг асуудлыг сургууль дээр ямар субъект хариуцах, хэрхэн зохион байгуулах талаар үлгэрчилсэн журам, заавар боловсруулж мөрдөөгүй, энэхүү үйлчилгээг хэрхэн санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалт дутмаг зэрэг сөрөг талууд байгаа нь тогтоогдсон.

Удирдлага, зохион байгуулалтын хувьд мэргэжлийн баримжаа олгож ирсэн уламжлалын дагуу сургуулиуд өөрсдийн боломж, нөөцөд тохируулан албан бус маягаар үйлчилгээг явуулдаг боловч мэргэжлийн баримжааны үйл ажиллагаа явуулах төв, танхим байдаггүй, түүнийг хэн хариуцах хэрхэн зохион байгуулах нь сургуулиудын хувьд нэгдмэл бус, үйлчилгээ нь тогтмолжоогүй байна.

Үйлчилгээний төрөл, агуулгын хувьд сургуулиуд төрөл бүрийн хичээлийн дугуйлан, сонгон хичээллүүлдэг сайн талтай боловч ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний агуулгыг сурагчдыг мэргэжлийн сургалтад хамруулах, мэргэжлийн сургуульд элсэхэд бэлтгэх гэсэн өрөөсгөл байдлаар ойлгож, энэ үйлчилгээг сурагчдын авьяас чадварыг нээн илрүүлэх, түүнд нь тохирсон мэргэжил сонгоход нь зөвлөн туслах, ирээдүйн эзэмших мэргэжил, гүйцэтгэх ажлын уялдаа холбооны талаар мэдээлэл өгөх гэсэн өргөн

хүрээнд нь авч үзэхгүй байна. Хөдөө болон хотын захын гэр хорооллын сургуульд үйлчилгээний төрөл, хэлбэр хязгаарлагдмал, элсэлтийн шалгалт болон их, дээд сургуулиудын мэдээлэл өгөх байдлаар хязгаарлаж буй. Мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаанд хэрэглэх гарын авлага, зөвлөмж хомс, сурагчдын авьяас чадварыг оношлох, хөгжүүлэх, түүнд тулгуурлан мэргэжил сонгоход нь зөвлөн туслах үйлчилгээ нэн хязгаарлагдмал.

Үйлчилгээний хүртээмж, үр өгөөжийн хувьд хоёр сурагч тутмын нэг нь мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээнд сэтгэл ханамжгүй, үр дүн муутай байдгаа илэрхийлжээ. Хотын захын болон хөдөөгийн жижиг сургуулийн сурагчид мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээнд сайн хамрагдаж чадахгүй байна. Сургууль багш нар сурагчдын мэргэжлээ сонгох, ажил мэргэжлийн талаар шийдвэр гаргахад дотнын туслагчийн үүрэг гүйцэтгэдэг байр сууриа сурагчдын гэр бүл, ах дүүсэд алдах хандлагатай байна. Сурагчид ирээдүйн ажил мэргэжлээ өөрсдийн авьяас чадвар, зан чанарт тохируулан ул үндэстэй сонголт хийхээс илүүтэйгээр өөрсдийн хүсэл, мөрөөдөл, сонирхол шохоорхолдоо хөтлөгдөн сонгож байгаа нь харагдлаа.

Зөвлөмж

- “Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээ” гэсэн ухагдахууны тодорхойлолтыг нарийвчлан гаргаж багш, сурагч, эцэг эхчүүдийг нэгдсэн ойлголттой болгох,
- “Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээ” гэсэн ухагдахууныг шинэчлэн тодорхойлохдоо сурагчдыг мэргэжлийн сургалтад хамруулах, мэргэжлийн сургуульд элсэхэд бэлтгэх гэсэн өрөөсгөл хандлагыг өөрчилж, энэ үйлчилгээг сурагчдын авьяас чадварыг нээн илрүүлэх, түүнд нь тохирсон мэргэжил сонгоход нь зөвлөн туслах, ирээдүйд эзэмших мэргэжил, гүйцэтгэх ажил хөдөлмөрийн уялдаа холбоог ойлгоход зөвлөн туслах гэсэн өргөн хүрээнд нь иж бүрэн байдлаар авч үзэх,
- Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний хамрах хүрээ, агуулга, зохион байгуулалт, санхүүжилтийн хэм хэмжээг тогтоосон эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, мөрдөж ажиллах,
- Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний агуулгыг мэргэжлийн

сургалт, амьдрах ухаан, албан бус сургалтын агуулгатай уялдуулан шинэчлэн боловсруулж мөрдөх,

- Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээг сургууль дээр хэн хариуцан зохион байгуулах, үр дүнг үнэлж, тайлагнах асуудлыг тодорхой болгох, үүнтэй холбоотой чиг үүргийг сургуулийн дотоод журамд оруулж хэвшүүлэх,
- Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээ явуулах анги, танхим байгуулах, түүнд хэрэглэх мэдээллийн хэрэгсэл, шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангаж өгөх,
- Сургуулиудад гаднын байгууллага, мэргэжлийн хүмүүстэй хамтран ажилладаг, түүгээр дамжуулан мэргэжлийн баримжааны үйлчилгээг өргөжүүлэн баяжуулдаг туршлагыг нэвтрүүлэх, уламжлал хэвшлийг бий болгох,
- Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний санхүүжилтийг шийдвэрлэхдээ хөдөөгийн болон хотын захын сургуулиудад томиолтын нэмэгдэл зардал тусгаж байх,
- БСШУЯ-нд ерөнхий боловсролын сургуулийн ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээг дагнан хариуцан ажилладаг мэргэжилтний ажлын байр, Боловсролын хүрээлэнд энэ талын судалгааны ажил дагнан эрхэлдэг судлаачийн ажлын байр бий болгох.

Ашигласан материал

Holland, J. L. (1997). *Making Vocational Choices: A Theory of Vocational Personalities and Work Environments*. 3rd Edition, Psychological Assessment Resources, Odessa.

Krumboltz . J. D. (1996). *A Learning Theory of Career Counseling*. Handbook of Career Counseling Theory and Practice. Davies-Black.

Parsons, F. (1909). *Choosing a vocation*. Boston: Houghton Mifflin

Super, D. E. (1983). *Assessment in Career Guidance: Toward Truly Developmental C.*